

JOBka аппликейшн ашиглах нөхцөлүүд

1. Ерөнхий зүйл

1.1 JOBka аппликейшний энэхүү Ашиглалтын нөхцөл (цаашид "Нөхцөл" гэх) нь Хэрэглэгчдийн ашиглах эрх, үүргийг зохицуулна.

1.2 JOBka Аппликейшн (цаашид "Аппликейшн" гэх) нь зөвхөн Компани доторх харилцаанд ашиглагддаг гар утасны аппликейшн юм.

1.3 Аппликейшний үйл ажиллагаа гэдэг нь энэхүү Нөхцөлийн дагуу бүртгүүлсэн Хэрэглэгчдэд уг аппликейшн хэрэглэгдэж үйлчлэхийг хэлнэ.

1.4 Нэр томьёо: Энэхүү Нөхцөлд том үсгээр бичигдсэн нэр томьёонууд дараах утгатай:

- **Аппликейшн** – Хэрэглэгчид Компаниас үзүүлэх болон бусад боломжит Модулиудыг ашиглах боломжийг олгодог гар утсанд суулгах зориулалттай JOBka аппликейшн;
- **Данс** – Аппликейшний үйлдлүүдийг ашиглах боломжтой Хэрэглэгчийн акаунт.
- **Суулгалт** – Аппликейшн дэмждэг App Store эсвэл Google Play-ээс Хэрэглэгчийн хувийн эсвэл албаны гар утсанд Аппликейшнийг сайн дураараа татаж авах
- **Бүртгэл** – Нөхцөлд зааснаар Аппликейшний үйлдлүүдийг болон Данс ашиглахын тулд Хэрэглэгч бүртгүүлэх үйл ажиллагаа;
- **Хэрэглэгч** – Аппликейшн ашиглаж байгаа Компанийн ажилтан эсвэл Компанийн агентлагийн ажилтан;
- **Администратор** – Хэрэглэгчийн Дансыг удирдах, Аппликейшнийг ажил олгогчийн нөхцөлд тохируулах, Үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллагатай харилцах, Аппликейшнийг дотоод журмын дагуу хөтөлж хариуцахаар Компаниас томилогдсон хүн;
- **Компани** - Foxconn Group-д багтдаг хуулийн этгээд - компаниуд:
 - FOXCONN CZ s.r.o.**, хаяг: U Zámečku 27, 530 03 Pardubice, УБД: 25938002, Храдэц Краловэ хот дахь Мужийн шүүхэд хөтлөгддөг Бизнес үйл ажиллагааны бүртгэлийн дугаар C 16095
 - Foxconn European Manufacturing Services s.r.o.**, хаяг: U Zámečku 27, 53003 Pardubice, УБД: 25965361, Храдэц Краловэ хот дахь Мужийн шүүхэд хөтлөгддөг Бизнес үйл ажиллагааны бүртгэлийн дугаар C 17934
 - GLOBAL SERVICES SOLUTIONS s.r.o.** Хаяг: U Zámečku 27, 53003 Pardubice, УБД: 27524850, Храдэц Краловэ хот дахь Мужийн шүүхэд хөтлөгддөг Бизнес үйл ажиллагааны бүртгэлийн дугаар C 24088
 - Foxconn Technology CZ s.r.o.**, хаяг: Karlov 245, 284 01 Kutná Hora, УБД: 27516032, Прага хот дахь Хотын шүүхийн Бизнес үйл ажиллагааны бүртгэлийн дугаар C 149895

Foxteq CZ s.r.o., Хаяг: U Zámecku 27, 53003 Pardubice, УБД: 17405459, Храдэц Краловэ хот дахь Мужийн шүүхэд хөтлөгддөг Бизнес үйл ажиллагааны бүртгэлийн дугаар С 49883

SafeDX s.r.o., Хаяг: K Žižkovu 813/2, Vysočany, 190 00 Praha 9, УБД: 04585119, Прага хот дахь Хотын шүүхийн Бизнес үйл ажиллагааны бүртгэлийн дугаар С 249253

- Аппликейшн нийлүүлэгч - JOBka services s.r.o., УБД: 08384681, хаяг: Sady Pětatřicátníků 173/31, Jižní Předměstí, 301 00 Plzeň

2. Аппликейшны тодорхойлолт

2.1 JOBka аппликейшн нь Хэрэглэгчдэд Компанийн дотоод мэдээлэл, дотоод систем, Компанитай харилцах харилцаа болон Компанийн онцлогийн дагуу бусад ашигтай үйлдлүүдэд нэвтрэх боломжийг олгодог.

2.2 Энэхүү Нөхцөлүүдийн “8. Аппликейшны үйлдлүүд”-д заасан тодорхой үйлдэл нь Компанийн шаардлагаас шалтгаалан өөрчлөгдөж болно.

2.3 Уг аппликейшн нь Android болон iOS-тэй гар утаснуудад зориулагдсан болно.

2.4 Хэрэглэгчид Чех, Англи, Монгол, Украин, Орос, Румын, Польш, Болгар, Вьетнам гэсэн есөн хэлээр үзэх боломжтой. Аппликейшн нь Хэрэглэгчийн гар утсанд тогтоосон хэл дээр автоматаар харагдана. Хэрэв Хэрэглэгч дээрх есөн хэлний нэгээс өөр хэл хэрэглэдэг бол Аппликейшн нь чех хэл дээр харагдана. Та өөрийн хүссэн хэлийг Settings kafест шууд App дээр өөрчилж болно.

3. Аппликейнд бүртгэл үүсгэх, нэвтрэх

3.1 JOBka Аппликейшнийг App Store (iOS-д) эсвэл Google Play (Android-д) -ээс Хэрэглэгчийн хувийн эсвэл Компаниас Хэрэглэгчид олгосон гар утас руу татаж аваад, дараа нь тусгай нэвтрэх мэдээллийг ашиглан бүртгүүлнэ. Уг аппликейшнийг үнэгүй авах боломжтой. Уг аппликейшн нь ажиллахын тулд дата эсвэл Wi-Fi холболт шаарддаг.

3.2 Хэрэглэгч бүр өөрийн хувийн мэдээллээр Аппликейшнд бүртгүүлдэг тул нэг Хэрэглэгч Аппликейшн дээр зөвхөн нэг Данс нээж болно.

3.3 Нэвтрэх мэдээллийг Компанийн myFOX дахь дотоод хүний нөөцийн системээр дамжуулан Хэрэглэгчид илгээнэ. Хэрэглэгч Аппликейшнд бүртгүүлэхийн тулд өөрийн хувийн дугаарыг (ID) оруулж, myFOX хүний нөөцийн системийн профайл дээрээс өөрт нь ирсэн тусгай QR кодыг сканэрдэж уншуулах ёстой.

3.4 Хэрэглэгч нэвтрэхдээ PIN код, Touch ID эсвэл Face ID ашиглан Аппликейшний аюулгүйн хамгаалалтын тохиргоог хийнэ.

3.5 Хэрэглэгч Профайлаас гарахдаа Хэрэглэгчийн профайл дээрх logout товчийг дарна.

3.6 Хэрэглэгч өөрийн бүртгүүлэх болон нэвтрэх мэдээллээ гуравдагч этгээд бүрүүгаар ашиглахаас хамгаалах үүрэгтэй. Хэрэглэгч бүртгүүлэх болон нэвтрэх мэдээллийг гуравдагч этгээдэд мэдэгдэж болохүй, аюулгүй байлгаж хамгаалах ёстой.

4. Аппликейшн ашиглалтыг дуусгавар болгох

4.1 Хэрэглэгч Аппликейшны “Асуулт” модульд эсвэл hrinformationsystems@cz.foxconn.com и-мэйл хаягаар Администратор буюу Хүний нөөцийн хэлтэс - HRIS Team-д Дансаа цуцлуулах хүсэлт гаргаж болно.

4.2 Хэрэв Хэрэглэгч нь Компанийн ажилтан эсвэл Компанийн агентурын ажилтан байхаа больсон бол, эсвэл ажилтан нь энэхүү Нөхцөлийг зөрчсөн эсвэл Аппликейшнийг ашиглахдаа Компанид хохирол учруулж болзошгүй бусад зохисгүй үйлдэл хийсэн бол Компани Хэрэглэгчийн дансыг цуцлах эрхтэй.

4.3 Хэрэв Хэрэглэгч Аппликейшн Нийлүүлэгчийн тогтмол оруулдаг мэдээллээс (24 цаг тутам) хасагдсан бол Хэрэглэгчийг болон түүний Дансыг автоматаар цуцлагдсан гэж ойлгоно. Ийм байдлаар тэмдэглэгдсэн Хэрэглэгч мэдээллийн санд дахиад 30 хоног үлдэж, дараа нь мэдээллийн сангаас бүрмөсөн устгагдана. Хэрэглэгчийг устгахтай хамт Хэрэглэгчийн данстай холбоотой бүх Хэрэглэгчийн мэдээлэл устгагдана.

5. Хэрэглэгчийн үүрэг хариуцлага

5.1 Хэрэглэгчид дараах зүйлсийг хориглоно:

- (a) Энэхүү Нөхцөл, Компанийн дотоод удирдамж, кодекс, хууль дүрэм журам эсвэл Компанийн эрх, ашиг сонирхлын эсрэг Аппликейшнийг ашиглах;
- (b) Аппликейшнээр дамжуулан хууль бус, ёс зүйгүй агуулга тараах, гуравдагч этгээдийн хувийн эрхийг зөрчих;
- (c) холбогдох хүний ил тод, нотлох зөвшөөрөлгүйгээр эмзэг мэдээлэл, хувийн мэдээллийг Аппликейшнээр дамжуулан хуваалцах, дамжуулах, хадгалах;
- (d) Аппликейшнийг өөрчлөх, түүний үйлдлүүдийг тасалдуулах;
- (e) Аппликейшн дотор эсвэл Аппликейшнээр дамжуулан аливаа хор хөнөөлтэй програм хангамж (вирус, Троян морь гэх мэт) эсвэл Аппликейшний үйл ажиллагаанд саад учруулах, эсвэл Аппликейшн болон түүнд агуулагдсан компанийн мэдээлэл аюул учруулах;
- (f) Аппликейшн дэх Дансанд нэвтрэх мэдээлэл эсвэл Аппликейшн эсвэл myFox хүний нөөцийн системээр үүсгэсэн мэдээллийг гуравдагч этгээд авах боломжтой болгох.

5.2 Хэрэв Хэрэглэгч Аппликейшнийг ашиглах Нөхцөлийг зөрчсөн нь тогтоогдвол Администратор тухайн Хэрэглэгчийн Аппликейшн дэх Дансыг тэр даруй блоклох буюу цуцлах бөгөөд учирч болох болон учирсан хохирлыг арилгах бүх арга хэмжээг авч болно. Хэрэглэгч

энэ тохиолдолд Компанид болон Администраторт шаардлагатай бүхий л баримтыг үзүүлж, хамтран ажиллах үүрэгтэй.

5.3 Хэрэглэгч нэвтрэх эрх, нууц үг хэрэглэх эрх нь зөрчигдсөн болон энэхүү Ашиглалтын Нөхцөлд заасан дүрэм зөрчигдсөн талаар Администраторт нэн даруй мэдэгдэнэ.

5.4 Аппликейшн тасалдах эрсдэлийг багасгахын тулд вирусын эсрэг програм хангамж, интернэт хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хамгаалах программ ашиглах зэрэг техникийн аюулгүйн зохих арга хэмжээг ашиглах ёстой.

5.5 Администратор Хэрэглэгчээс нууц үгээ утсаар эсвэл и-мэйлээр өгөхийг хэзээ ч хүсэхгүй.

6. Хувийн мэдээлэл

6.1 Компани нь Европын парламент болон Европын холбооны зөвлөлийн “Хувийн мэдээлэлтэй харьцахтай холбоотойгоор хувь хүнийг хамгаалах болон мэдээллийн чөлөөт хөдөлгөөний тухай” 2016/679 тоот захирамж, Хувийн мэдээлэл боловсруулах тухай 110/2019 тоот хууль, Хувийн мэдээлэл боловсруулах тухай хууль батлагдсанаар зарим хуульд өөрчлөлт оруулах тухай 111/2019 тоот хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

6.2 Хувийн мэдээлэл боловсруулах ажлын зорилго нь Компани болон ажилтнууд/агентлагын ажилтнуудын хооронд мэдээллийг илүү хурдан, илүү үр дүнтэй хуваалцах боломжийг олгох Компанийн дотоод харилцааг хангахад оршино. Боловсруулсан мэдээлэлд тодруулбал: хувийн дугаар, ажилтан/агентлагын ажилтны нэр, овог, ажлын нэр, и-мэйл, утасны дугаар, харилцах хэл багтдаг.

6.3 Хэрэглэгч хувийн мэдээлэл хамгаалах, түүнд нэвтрэх, залруулах, боловсруулалтыг хязгаарлах, устгах эрхтэй танилцсан гэдгээ баталж байна.

6.4. Аппликейшнийг ашиглан хувийн мэдээллийг боловсруулах тухай дэлгэрэнгүй мэдээллийг FoxPortal-ийн дотоод системээс GDPR хэсэг, Хувийн мэдээлэл боловсруулах тухай мэдээлэл – "JOBka аппликейшн дэх ажилтнуудын хувийн мэдээллийг боловсруулах тухай мэдээлэл" гэсэн тэмдэглэгээтэй баримт бичгээс [GDPR – Хувийн мэдээлэл боловсруулах тухай мэдээлэл – Foxportal](#) хаягаар орж үзнэ үү.

7. Техникийн шаардлага

7.1 Аппликейшнийг гар утасны аппликейшн Google Play эсвэл App Store-ээс татаж болно.

7.2 Гар утасны хувьд дараах үйлдлийн системийн хувилбарууд шаардлагатай: Android 7.0 болон түүнээс дээш хувилбар, эсвэл iOS 11 болон түүнээс дээш хувилбар.

7.3 Компани Аппликейшнийг татаж авах болон ашиглахад ямар ч хураамж авдаггүй. Харин Хэрэглэгч Аппликейшнийг хувийн гар утас дээрээ ашиглавал Аппликейшнийг татаж авах, эхлүүлэх, ашиглахад шаардагдах өгөгдөл дамжуулах зардлыг үүрэн телефоны операторынхоо тарифын дагуу төлбөр хийнэ.

7.4 Ажилтан Аппликейшнийг зөвхөн зөвшөөрөгдсөн төхөөрөмжүүд дээр болон Компанийн аюулгүй байдлын дотоод дүрмийн дагуу ашиглах үүрэгтэй.

7.5 Компани аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалт, дотоод удирдамжийг дагаж мөрдөх зорилгоор Аппликейшнийг ашиглахад хяналт тавьж болно. Хяналт нь хуулийн дүрэм журам болон хувийн нууцыг хамгаалах журмын дагуу явагддаг.

8. Аппликейшны үйлдлүүд (модулиуд)

Аппликейшний тус тусын үйл ажиллагаа нь доор заасан зорилгын дагуу болон үүний үр дүнд бий болсон ашиглалтын дүрмийн дагуу ажилладаг.

8.1. МОДУЛЬ Мэдээ мэдээлэл

- a) Модуль нь компанийн үйл ажиллагааны шинж чанартай мэдээллийг хуваалцахад ашиглагддаг. Хэрэв Хэрэглэгч модулиар дамжуулан компанийн үйл ажиллагааны мэдээллээс өөр мэдээлэл хүлээн авбал Администратортой даруй холбоо барих үүрэгтэй.
- b) Өгөгдсөн бүх мэдээлэл нь нууц бөгөөд зөвхөн Компанийн дотоод үйл ажиллагаанд зориулагдсан. Хэрэглэгч энэ модулиар дамжуулан хүлээн авсан мэдээ, мэдээллийг гуравдагч этгээдүүд болон Компанид тухайн мэдээллийг авах эрхгүй бусад хүнтэй хуваалцаж болохгүй. Мөн энэ модулиар дамжуулан авсан мэдээллийг Хэрэглэгч Компанийн тодорхойлсноос бусад харилцааны сувгуудаар дамжуулж эсвэл тарааж болохгүй. Энэ нь мөн мэдээ мэдээлэлд хавсаргасан бусад баримт, хавсралтад ч хамаатай.
- c) Мэдээ мэдээлэл нь Хэрэглэгчид зохисгүй, гутаан доромжилсон, Компанийн дүрэм, Компанийн ёс зүйн кодекстэй зөрчилдсөн эсвэл ёс суртахуунгүй байвал Хэрэглэгч Администратортой даруй холбоо барих үүрэгтэй.

8.2. МОДУЛЬ Манай урамшууллууд

- (a) Модуль нь Хэрэглэгчдэд Компаниас үзүүлдэг хөнгөлөлт, урамшууллын талаар мэдээлэхэд ашиглагддаг.
- (b) Компанид ажиллах хүсэлтэй хүмүүсийг шинэ ажлын байранд санал болгох, шинэ ажилтан элсүүлсэний урамшуулал авах тухай мэдээллийг мөн Хэрэглэгчдэд хүргэнэ.
- (c) Хөнгөлөлт, урамшууллын мэдээллийг Хэрэглэгч гуравдагч этгээдүүд, өрсөлдөгч компаниудад тараахгүй байх, эсвэл зөвхөн Компанийн шинэ ажлын байр танилцуулах зорилгоор өөр хүнд танилцуулж болно.
- (d) Компани нь хөнгөлөлт урамшууллын тухай мэдээллийг өөрчлөх эсвэл шинэчлэх эрхтэй бөгөөд өөрчлөлтүүдийг ямагт Аппликэшнээр мэдэгдэх болно.

8.3. MODULE Асуулга судалгаа

- (a) Модуль нь Компани дахь ажлын орчин, дүрэм, сэтгэл ханамж болон компанийн дотоод бусад сэдвүүдийн талаарх Хэрэглэгчдийн үзэл бодлыг олж мэдэхэд ашигладаг.
- (b) Судалгаанд оролцох нь бүрэн сайн дурын үндсэн дээр бөгөөд Хэрэглэгч асуулгад заавал оролцох албагүй.
- (c) Нээлттэй асуулт байвал Хэрэглэгчийн хариулт нь эелдэг, ёс зүйтэй байх ёстой бөгөөд гутаан доромжилсон, зохисгүй агуулга, дотоод эмзэг мэдээлэл (худалдааны нууц, гуравдагч этгээдийн хувийн мэдээлэл гэхчлэн) агуулахгүй байх ёстой.
- (d) Хэрэв Хэрэглэгч зөвшөөрөлгүй, зохисгүй агуулга, асуулт (эмзэг мэдээлэл, үйлдвэрлэлтэй холбоотой) агуулсан судалгаа хүлээн авбал Хэрэглэгч энэ талаар Администраторт даруй мэдэгдэх үүрэгтэй.
- (e) Судалгаа нь зөвхөн Компанийн дотоод хэрэгцээнд зориулагдсан бөгөөд ажилтнууд судалгаа, хариултыг гуравдагч этгээдүүдтэй хуваалцах, зөвшөөрөлгүйгээр тарааж болохгүй.

8.6. MODULE Ажлын байрны санал

- (a) Ажлын байрны санал модуль нь Хэрэглэгчдэд Компанид ажилд орох шинэ нэр дэвшигчдийг санал болгох боломжийг олгодог.
- (b) Хэрэглэгч зөвхөн Нөхцөл дүрмүүдийг зөвшөөрсөн нэр дэвшигчдийг санал болгож болно.
- (c) Нэр дэвшигчийн өгсөн мэдээллийн үнэн зөв байдлыг Хэрэглэгч хариуцна.
- (d) Хэрэглэгч зөвхөн тухайн ажлын байрны шаардлага хангасан нэр дэвшигчдийг санал болгох ёстой.
- (e) Компани нэр дэвшүүлсэн шинэ хүнийг судалж, дараагийн алхмуудыг шийдэх эрхтэй.

8.6. МОДУЛЬ Асууж лавла

- (a) Компанийн дотоод журам, дүрэмтэй холбоотой болон Хэрэглэгчийн ажил төрөлтэй хамаарах асуултыг Компаниас Хэрэглэгч асууж лавлахад зориулагдана.
- (b) Нэрээ нууцлахгүй асуух бөгөөд асуугчийн нэр, овог, хувийн дугаар ил тод байна.

- (c) Тухайн асуултыг асуухаасаа өмнө Хэрэглэгч өмнө нь уг асуулт тавигдаж Компаниас хариулт өгч байсан эсэхийг хайлт хийж (ж нь, компанийн интранет, дотоод заавар г.м.) үзэх хэрэгтэй. Ингэснээр Администраторуудад хэт их ачаалал өгөхөөс зайлсхийх ач холбогдолтой.
- (d) Асуултыг соёлтой, тодорхой, бодитойгоор бичнэ. Зохисгүй, доромжилсон, модульны зорилготой холбоогүй асуултуудыг оруулж болохгүй. Хүсэлтэд дотоод эмзэг мэдээллийг (санхүү, цалингийн мэдээлэл, худалдааны нууц, гуравдагч этгээдийн хувийн мэдээлэл гэхчлэн) оруулж болохгүй.
- (e) Компани нь гутаан доромжилсон, бүдүүлэг асуултад хариулахгүй байх эрхтэй.
- (f) Хэрэв Хэрэглэгч өөрийнх нь асуултад доромжилсон хариу хүлээн авбал энэ талаар Администраторт тэр даруй мэдэгдэнэ.

8.7. МОДУЛЬ Зах

- (a) Компанийн Зах зөвхөн Компанийн ажилтнуудад зориулагдсан.
- (b) Зах дээр зарлагдах зүйлсийн талаарх мэдээллийг зөвхөн компанийн Application-ээр дамжуулан авах боломжтой.
- (c) Хэрэглэгчдийн хувийн зар сурталчилгааны зориулалтаар ашиглагддаг бөгөөд Аппликейшний Ашиглалтын ерөнхий нөхцөл, Захаар үйлчлүүлэх Компанийн дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-д захирагдана.

9. Зах МОДУЛИЙГ АШИГЛАХ ДҮРЭМ

9.1. Компани болон Хэрэглэгчийн эрх, үүрэг

- (a) Хэрэглэгч Зар сурталчилгааны агуулгын хариуцлагыг хүлээнэ. Компани Зар сурталчилгааны агуулгын талаар хариуцлага хүлээхгүй.
- (b) Хэрэглэгч Зар сурталчилгаа тавихдаа энэхүү Нөхцөл, холбогдох хуулийн дүрмүүдийг дагах үүрэгтэй.
- (c) Хэрэглэгч Зар сурталчилгааны агуулга болон / эсвэл Зар сурталчилгаанд хавсаргасан гэрэл зураг болон бусад файлууд нь гуравдагч этгээдийн эрхийг зөрчихгүй байхад анхаарах үүрэгтэй. Хэрэглэгч гуравдагч этгээдийн эрхд хөндлөнгөөс оролцсон тохиолдолд Компани хариуцлага хүлээхгүй.
- (d) Хэрэглэгч өөрийн авсан гэрэл зургийг Зар сурталчилгаанд хавсаргасан тохиолдолд уг Зар Аппликейшнд байх хугацааны туршид зургаа ашиглуулахыг зөвшөөрсөн гэж, мөн энэ Нөхцөлүүдийг зөвшөөрсөнд тооцогдоно.
- (e) Зар тавьсан өөр хүний хэрэглэсэн зургийг Хэрэглэгч өөрийн зардаа ашиглаж болохгүй.
- (f) Зар сурталчилгаанд Хэрэглэгч санал болгож буй бараа, үйлчилгээний тухай бүрэн бөгөөд үнэн зөв мэдээлэл, түүний дотор барааны үйл ажиллагаа, аливаа эвдрэл, элэгдэл, согог, бараа борлуулалт, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийн тухай мэдээллийг өгөх үүрэгтэй.

- (g) Зар сурталчилгаа оруулахдаа Хэрэглэгч бөглөх ёстой мэдээллүүдийг бөглөх үүрэгтэй. Мөн и-мэйл хаяг эсвэл утасны дугаараа үнэн зөв бичих ёстой.
- (h) Хэрэглэгчийн оруулсан Зар сурталчилгаа аппликейшн дээр тодорхойгүй хугацаагаар байна. Компани тухайн тавигдсан Зарын хугацааг өөрчлөх эрхтэй.
- (i) Хэрэглэгч хөдөлмөрийн харилцаагаа цуцлах эсвэл Аппликейшн рүү нэвтрэх эрхээ цуцалсан тохиолдолд (Хэрэглэгчийн өөрийнх нь хүсэлтээр ч бас) Зар сурталчилгаа 5 хоногийн дотор автоматаар устгагдана.
- (j) Хэрэглэгч өөрийн тавьсан Зар сурталчилгааг хүссэн үедээ устгах эрхтэй.
- (k) Хэрэглэгчийн устгасан Зар сурталчилгаа Аппликейшн дээр харагдахаа больж, мөн админуудад ч харагдахгүй болно.
- (l) Сонирхсон тал Хэрэглэгчийн оруулсан Зар сурталчилгааны хэсэгт тайлбар бичих замаар холбоо барьж болно. Хэрэв Хэрэглэгч Зар сурталчилгаанд и-мэйл хаяг, утасны дугаарыг оруулбал Сонирхогч эдгээрээр холбоо барьж болно.
- (m) Компани нь санал болгож буй бараа, / эсвэл үйлчилгээний чанар, гарал үүслийн талаар ямарваа баталгаа гаргахгүй, хариуцлага хүлээхгүй. Хэрэглэгч, Сонирхогч хоёрын хоорондын харилцаа нь Иргэний хуулийн 89/2012 дугаар хуулийн заалтаар зохицуулагдана. Бараа хүргэх, хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх, бараа, үйлчилгээний төлбөр төлөх хариуцлагыг Хэрэглэгч болон Сонирхогч талууд хариуцна.
- (n) Энэхүү Нөхцөлийг хангаагүй эсвэл хуулийн дүрэм, түүний дотор Компанийн дотоод хууль тогтоомжийг зөрчсөн Зар сурталчилгааг Компани урьдчилан мэдэгдэлгүйгээр устгах эрхтэй. Компани нь мөн энэхүү Нөхцөлийн аль нэг заалт, зохих хууль журмуудыг, түүний дотор Компанийн дотоод эрх зүйн дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд Хэрэглэгчийг Зах модульд нэвтрэхийг хориглох эрхтэй.
- (o) Компанийн эсвэл гуравдагч талын хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор шаардлагатай бол Компани Зар сурталчилгааг устгах эрхтэй.
- (p) Зохисгүй Зар сурталчилгаа байвал энэ талаар админд Хэрэглэгч бүр мэдэгдэж болно, 9.4.2-ыг үзнэ үү.

9.2. Зах МОДУЛЬ -д зөвшөөрөгдөх зүйлс

- (a) Бараа бүтээгдэхүүний санал (цахилгаан хэрэгсэл, хувцас, спорт тоног төхөөрөмж, ном г.м.).
- (b) Жирийн хэрэглээнд тохирох бараа, үйлчилгээний эрэлт.
- (c) Хуулийн дагуу үзүүлж болох үйлчилгээнүүд (нэмэлт хичээл, бага зэргийн засвар гэх мэт).

9.3. Зах МОДУЛЬ-д хориглох зүйлс

- (a) Хориотой болон хууль бус бараа (архи, тамхи, зэвсэг, мансууруулах бодис г.м.) борлуулах.
- (b) Компанийн дотоод эрх зүйн дүрэм журмыг зөрчсөнтэй холбоотой санал, эрэлт.
- (c) Зохисгүй, доромжилсон эсвэл ялгаварлан гадуурхсан агуулгатай зүйл.
- (d) Арилжааны зар сурталчилгаа, бизнесийн үйл ажиллагааг сурталчлах.
- (e) **Компанийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд хэрэглэгддэг эд анги, материал санал болгох.**

9.4. МОДУЛЬ захыг шалгах, залруулах арга хэмжээ авах

Зах дээр гарч байгаа зүйлсийн агуулгыг Компаниас томилогдсон хүн хариуцаж тохиолдлын шалгалт хийнэ.

Компани нь Хэрэглэгчдийн Зах модульд оруулсан бүх зүйлийн агуулга, нийтлэгдсэн зар сурталчилгаа, тэдгээрт бичигдсэн сэтгэгдлийг шалгах эрхтэй.

9.4.1. Зохисгүй агуулга илэрвэл дараах арга хэмжээг авна:

- (a) **Дүрэм эхний удаа зөрчихөд:** Зохисгүй агуулгыг анхааруулах, устгах.
- (b) **Дүрэм давтан зөрчихөд:** Хэрэглэгч Захад нэвтрэх эрхийг түр хугацаагаар хаах (30 хоног хүртэл).
- (c) **Дүрэм ноцтой зөрчихөд:** Зах болон Аппликейшнд нэвтрэх боломжийг бүрмөсөн хаах, мөн Компанийн дотоод журам, Хөдөлмөрийн болон бусад хууль журамд үндэслэн бусад арга хэмжээ (Анхааруулах хуудас өгөх г.м.) авах

Компанийн дотоод журам, Хөдөлмөрийн болон бусад хууль журмыг зөрчсөн ноцтой зөрчил гэдэг нь, Компанийн Ёс зүйн журам зөрчих, эсвэл Компанийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд хэрэглэгддэг эд анги, материал санал болгох зэрэг тооцогдоно.

9.4.2. Зохисгүй агуулгатай зарын талаар мэдэгдэх

- (a) Зохисгүй агуулгатай зарын талаар Асуух лавлах модулиар дамжуулан Хэрэглэгч бүр Админд мэдэгдэх буюу Компанийн Комплаинс хэлтэст гомдол гаргаж болно.
- (b) Гомдлын ноцтой байдлаас шалтгаалан дээд тал нь ажлын 5 хоногийн дотор Админ зохих арга хэмжээг авна.

10. Аппликейшний ашиглалтын нөхцөлд өөрчлөлт хийх

10.1 Ажил олгогч нь Аппликейшний энэхүү Ашиглалтын Нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй. Нэмэлт өөрчлөлтүүд хэвлэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

10.2 Хэрэглээний одоогийн Ашиглалтын Нөхцөл нь Аппликейшн дээр зохих бүлэгт байдаг бөгөөд Хэрэглэгч хэдийд ч уншиж танилцаж болно.

10.3 Энэхүү Аппликейшний Ашиглалтын Нөхцөлд хамрагдахгүй асуудлууд нь Компанийн дотоод дүрэм журам болон хүчин төгөлдөр бусад хууль журмаар зохицуулагдана.

11. Холбоо барих

11.1 Хэрэглэгчид Аппликейшний үйл ажиллагаатай холбоотой бүх асуулт, санал хүсэлтийн талаар Компанийн хүний нөөцийн хэлтсийн дараах ажилтнуудтай холбоо барьж болно:

Ирена Томкова: itomkova@cz.foxconn.com, утас: 733 593 425

Зузана Биттнер: zbittner2@cz.foxconn.com, утас: 737 235 297

11.2 Дүрэмд заасан тодорхой тохиолдолд Хэрэглэгчид Администратортой холбоо барьж болно.

11.3 Техникийн асуудал гарвал Аппликейшн нийлүүлэгч компани болох JOBka services ХХК., УБД: 08384681, Sady Pětatřicátníků 173/31, Jižní Předměstí, 301 00 Plzeň хаяг руу Миний JOBka ертөнц бүлгээр дамжуулан мэдэгдэл шууд илгээж болно.

12. Төгсгөл

12.1 Хэрэглэгч Аппликейшнийг нээж хэрэглэж эхэлснээрээ дараах зүйлсийг зөвшөөрч баталгаажуулсанд тооцогдоно:

- (a) Аппликейшний Ашиглалтын Нөхцөлийг уншиж, ойлгосон;
- (b) Хэрэглээний модулиудын зорилгыг ойлгож, ашиглах дүрмийг зөвшөөрсөн;
- (c) Аппликейшнийг ашиглахтай холбоотойгоор хувийн мэдээлэлтэй нь харьцахыг зөвшөөрсөн;
- (d) Хэрэв тэрээр Аппликэшнд бүртгүүлбэл Компани болон түүний шууд дарга энэ бүртгэлийг хянаж байх болно гэдгийг зөвшөөрнө. Энэ нь удирдах ажилтнууд хоорондоо харилцах бүлэг үүсгэхэд зайлшгүй чухал. Бүртгэгдсэн Хэрэглэгчдийн талаар мөн Компанийн Администраторуудын баг мэдэж байх ёстой, ингэснээр харилцаа мэдээлэл солилцоо, Данс зохицуулах, бүртгэлжилтийн үнэлгээ, асуулга судалгаа, уралдаан тэмцээн зохион байгуулах, шагнал гардуулах зэрэгт ашиглах юм.
- (e) Аппликейшнийг ашиглах энэхүү Нөхцөл, Компанийн ёс зүйн кодекс болон Аппликейшнийг ашиглахдаа аюулгүй байдлын зарчимтай холбоотой Компанийн дотоод бусад дүрэм журмуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

12.2 Техникийн шалтгаанаар үүссэн Аппликейшний үйл ажиллагааны эвдрэл, тасралт, түүний дотор Хэрэглэгчийн төхөөрөмж дээрх үйлдлийн системд өөрчлөлт гарсан эсвэл уг төхөөрөмж дээрх бусад програм хангамж тохирохгүй болсон тохиолдолд Компани хариуцлага хүлээхгүй.

12.3 Интернет болон Компанийхаас бусад гадны вэбсайтууд сүлжээгүй болсноос үүдсэн техникийн сааталд Компани хариуцлага хүлээхгүй.

12.4 Аппликейшнийг ашиглах буюу Аппликейшний энэхүү Ашиглалтын Нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр Аппликейшнд мэдээлэгдэх зүйлсийн оюуны өмчийн эрх, түүний дотор график хэсгүүдийн зохиогчийн эрх, Аппликейшн эсвэл түүний нэг хэсгийн зохиогчийн эрх Хэрэглэгчид шилжихгүй.

12.5 Аппликэшн дээр гарсан зүйлийг аливаа байдлаар ашиглах нь зөвхөн Компанийн урьдчилсан зөвшөөрлийн үндсэн дээр болно.

12.6 Аппликэшний энэхүү Ашиглалтын нөхцөлүүд нь 2025.02.21-нээс хүчин төгөлдөр болно.